



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 25 өдөр

Дугаар

A/861

Ховд

Дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а” дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Спорт заалын барилга, 250 суудал /Ховд, Дарви сум/-н ажилд гүйцэтгэгч, ашиглагчаас гаргасан саналын дагуу нягтлан шалгаж зураг төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	
Н.Ганзориг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Д.Эрдэнэбат	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтан
Г.Цэдэнбал	-Монгол Улсын гавьяат барилгачин
С.Бямбасүрэн	-Барилгын зураг төслийн “Алтайн газрын хүч”ХХК-ийн захирал
О.Ганцоож	- Дарви сумын Засаг дарга


Нарийн бичгийн  
дарга Д.Тогтохбаяр

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын Барилга хот байгуулалтын  
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2.Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3.Дээрх ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН